

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 05

## Арвайхээр сүм

## Хэлэлцсэн нь:

1. Төвийн гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт явуулах тухай хэлэлцэх
  2. Зар мэдээ тавих, хавсралт мэдээллийн талаар танилцуулах
  3. Нэр дэвшигчдээс асуух асуулт боловсруулах гишүүдийн нэрс тодруулах

## Шийдвэрлэсэн нь:

1. Төвийн гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах зарыг 2022 оны 9 дүгээр сарын 6-ны дотор багтаан холбогдох мэдээллийн хэрэгслээр зарлах зар тавихыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Сумъяад даалгасугай.
  2. БОЭТ-ийн гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулахад Нэр дэвшигчдээс асуух сорилын болон ярилцлагын шалгалтын асуулт, бичгийн шалгалт, даалгавар, тэдгээрийн хариулт (түлхүүр)-ийг боловсруулах багийг ТУЗ-ийн гишүүн Т.Эрдэнэтунгалаг, Т.Мөнхбат, Т.Адъяатөмөр нарыг оролцуулан байгуулсугай.
  3. Эмнэлгийн гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг холбогдох дүрэм журмын дагуу хүлээн авч, үнэлэх бэлтгэл ажлыг хангахыг ТУЗ-ийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.
  4. БОЭТ-ийн танилцуулга, мэдээлэлд ТУЗ-ийн гишүүдээс гаргасан саналыг тусган эцэслэн боловсруулахыг нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.

